- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/177 дугаар тушаалаар Киоск тоног төхөөрөмжийг орон нутгийн Нийгмийн даатгалын хэлтэст үндсэн хөрөнгөд бүртгэж, оны эцсийн хөрөнгийн тооллогод байгаагаар тоолсон боловч, хөрөнгө бодитоор ирээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 386.8 сая, эцсийн үлдэгдэл 16.1 сая төгрөг болж, 370.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №..... Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Бусад өглөг	12.7	9.08	(3.61)	56.23
Өндөр настны тэтгэвэр	2.37	2.16	(0.21)	13.37
Тахир дутуу тэтгэвэр	1.99	2.29	0.3	14.18
ХЧТА	254.2	-	(254.2)	
ЖА	111.09	-	(111.09)	
ҮО-ХЧТА	2.29	-	(2.29)	
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	0.78	0.78	0	4.83

Улс ӨН тэтгэвэр	1.23	1.69	0.46	10.46
Улс тахир дутуу тэтгэвэр	0.13	0.13	0	0.8
Нийт дүн	386.78	16.15	(370.7)	100

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 16.15 сая төгрөгийн өр байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 357.1 сая, эцсийн үлдэгдэл 357.1 сая төгрөг буюу өөрчлөлтгүй байна.

Хүснэгт № 31. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	357.1	357.1	0	1.4
Өмч /төрийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/				
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/				
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/				
Хуримтлагдсан үр дүн	22,834.2	25,825.1	2,990.9	98.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74.3	74.3	0	0.2
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
Дүн	23,265.6	26,256.5	2,990.9	100

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 74.3 сая төгрөгт өөрчлөлт ороогүй байна.

Хуримтлагдсан үр дүн 25,825.1 сая төгрөг болж 2,990.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 2,930.6 сая төгрөг, нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт 60.3 сая төгрөг бүртгэснээс шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд өмнөх оны актын орлого 72.6 сая, илүү төлсөн шимтгэлийн буцаалт 12.3 сая төгрөгийн зөрүүгээр 60.3 сая төгрөгийн залруулга байна.

3.5.10 Орлогын данс

Нийгмийн даатгалын сангийн дансанд тэтгэврийн даатгалын шимтгэл 83,555.6 сая, тэтгэмжийн даатгал 8,318.9 сая, YOMШ-ийн өвчний даатгалын шимтгэл 10,860.2 сая, ажилгүйдлийн даатгалын шимтгэл 1,697.2 сая, эрүүл мэндийн даатгалын шимтгэл 18,184.2 сая, нийт 122,616.1 сая төгрөгийн орлого төвлөрсөн.

Мөн сангийн хүүгийн орлого 9.3 сая, алдангийн орлого 37.3 сая, торгуулийн орлого 5.1 сая, сангийн бусад орлого 1.9 сая, нийт 53.6 сая төгрөгийн орлого орсон байна.

Нийгмийн даатгалын байгууллагын хувьд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 703.2 сая, нэмэлт санхүүжилтийн дансанд 67.3 сая, архивын лавлагааны орлого 0.4 сая төгрөг нийт 770.9 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

3.5.11 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 6.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Аудитын тайлангийн 3.9 дүгээр хэсэгт аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн хэсгийн Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага хэсэгт дэлгэрэнгүй оруулав.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд сангийн орлогыг 88,502.2 сая төгрөг, нийт зарлагыг 130,027.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, байгууллагын урсгал зардалд 1,165.4 сая төгрөг, санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,165.4 сая төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс сангийн орлогыг 13,426.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 101,928.6 сая төгрөгөөр, сангийн зардлыг 19,763.5 сая төгрөгөөр бууруулж 110,264.1 сая төгрөгөөр, байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг 699.1 сая төгрөгөөр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/10 дугаар тогтоолоор баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 110,963.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 699.1 сая төгрөгийг урсгал зардалд, 110,264.1 сая төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 16-ны А/56, 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/102, 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/175 дугаар тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/22 дугаар тогтоолоор тодотгол орж сангийн орлогыг 101,928.6 сая, зарлагыг 110,489.6 сая төгрөгөөр, үйл ажиллагааны урсгал зардлыг 703.2 сая төгрөгөөр төсөвт тодотгол хийсэн байна.

Баталсан орлогын төлөвлөгөөний 101,928.6 сая төгрөгт улсын төсвөөс олгох хөрөнгө 18,929.4 сая төгрөг батлагдсан ба сангийн бүрдүүлэх цэвэр орлого 82,999.2 сая төгрөг байна.

Нийт зардлын 703.2 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, сангийн орлогыг 101,928.6 сая төгрөгөөр, зарлагыг 110,928.6 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас 703.2 сая төгрөгийн санхүүжилт бүрэн олгосон, нийгмийн даатгалын санд 102,066.7 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй ч гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 37.3 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 0.4 сая төгрөгийг бүрдүүлсэн.

Байгууллагын урсгал зардлын төсвийн зардлын гүйцэтгэл 700.9 сая төгрөг буюу 99.69 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.9 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж, 2.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Сангийн зардлын гүйцэтгэл 110,489.6 сая төгрөг зарцуулахаас 109,676.9 сая төгрөг зарцуулж 812.7 сая төгрөгийг хэмнэсэн.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 7.1 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 59.9 сая, дээд шатны төсвийн захирагчаас 0.3 сая, нийт 67.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэргийн материалд 1,685.0 мянга, тээвэр шатахуунд 900.0 мянга, шуудан холбоонд 150.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлд 1,575.0 мянга, ажилчдын цалинд 62,965.3 мянга, нийт 67,275.3 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 143 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийн хугацаа болоогүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож, 165.6 сая төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй байсныг аудитын явцад залруулан нөхөж мэдээлүүлсэн.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 4.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 23.8 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	4.4	1	4.4			
Зөвлөмж	3	23.8	3	23.8			
Нийт	4	28.2	4	28.2			

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа Нийгмийн даатгалын хэлтсийн төсвийн байгууллага, нийгмийн даатгалын сангийн нийт 2 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргасан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 174.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 165.6 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 1.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7.7 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлжээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Шилэн дансны цахим сайтад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын 547.6 сая төгрөгийн мэдээлэл оруулахаас 165.6 сая төгрөгийн 3 ажил гүйлгээ орхигдуулсныг аудитын явцад залруулан бүртгүүлсэн.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

- Сангийн ерөнхий нягтлан бодогч нь 2021 оны 4 дүгээр сард ээлжийн амралтын нөхөн олговроо цалинтай хамт авсан байтал дараа сарын цалин бүтэн бодогдож 8 сард ээлжийн амралтын 15 хоногийг суутган тооцсон бол үлдсэн 5 хоногийн цалин 328,445 төгрөгийг давхардуулан олгосон.
- Тэтгэврийн байцаагч ажлын 24 хоногийн ээлжийн амралтын нөхөн олговроо 7 дугаар сард бодуулж авсан. 7 дугаар сард 18 хоног амарч, 8 дугаар сараас эхлэн цалинг бүтэн ажилласнаар бодож ээлжийн амралтын 6 хоногийн 332,178 төгрөгийн цалин давхардуулан олгосон.
- Хамралт орлого шимтгэлийн тасгийн дарга нь 2021 оны 8 дугаар сард 24 хоногийн ээлжийн амралтын нөхөн олговроо авсан. 08 дугаар сард 15 хоног амарч, дараа саруудад цалин бүтэн бодогдож 9 хоногийн 683,730 төгрөгийн цалин давхардсан байна.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ” гэж заасан заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтын нөхөн олговор, цалин давхардуулан авсан 1,344,353 төгрөгт төлбөрийн акт тогтоов.

ЗГ-ын 2021 оны 67 дугаар тушаалаар баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийн 10.3-т “Төв болон орон нутгийн комиссын бүрэлдэхүүнд гурваас дээш жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан магадлагч эмч, төв комиссын дарга, нарийн бичгийн даргад 3 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас 3 жил тутамд олгоно” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Б/67 тушаалаар магадлагч эмч Б.Пүрвээд 2,374,596 төгрөгийн тэтгэмжийг үндсэн цалингийн зардлаас олгож төсвийг зориулалт бус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” зааврын 210101-Үндсэн цалин “Цалингийн сүлжээ, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа үндсэн болон байнгын гэрээт ажилтны албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/22 дугаар тушаалаар Орхон аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн бүтэц орон тоог 38 ажилтантай, үүнээс орлого шимтгэлийн тасаг 9 хүний бүрэлдэхүүнтэй, сумын байцаагч 1, нийт 10 орон тоотой байхаар батлагдсан. Байгууллагын төсөвт орлогын тасгийн байцаагчийн урамшуулалд нэг ажилтанд 360.0 мянган төгрөгөөр бодож 9 ажилтанд нийт 2,880.0 мянган төгрөг олгохоор батлагдсан. Харин гүйцэтгэлээр урамшууллыг 14 ажилтанд 205,700 төгрөг

олгосон нь /өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан ажлын үүргийн хуваарилалтыг хийснээс шалтгаалсан гэх боловч/ НДЕГ-аас баталсан бүтэц орон тоог баримтлан ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

Төвлөрүүлэн захирагчид аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нийгмийн даатгалын сангийн авлага, өр төлбөрийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Тодруулга тайлантай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлэхдээ Сангийн сайдын 388 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгыг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй.

3.1.2 Эрсдэл: Санхүүгийн тайлангаас мэдээлэл бүрэн авахгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэн тайлагнаж байх.

3.2 Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Нийгмийн даатгалын сан нь өмнөх онд 14,071.5 сая төгрөгийн авлагатай байсан бол 2,479.3 сая төгрөгөөр нэмэгдэж 16,550.8 сая төгрөг болсон. Өр төлбөр 386.8 сая төгрөгөөс 16.1 сая төгрөг болж буурсан байна. Бүртгэлтэй өглөг, авлагын тооцооноос насжилт ихтэй 2017, 2018, 2019 онуудад үүссэн авлага 1,760.9 сая төгрөг, өр төлбөрийн 16.15 сая төгрөг бүрэн барагдаагүй байна.

3.2.2 Эрсдэл: Насжилт ихтэй, найдваргүй авлага, өр төлбөр бий болох.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Насжилт ихтэй авлага, өр төлбөрийг бүрэн барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 25-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Т.БОЛОРМАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.НАРМАНДАХ

ОРА-2022 /1/НА-СТА-ТТЗ

21

6117143690
ФАА0073 9042606

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан	Аудитын код:
			ОРА-2022/1/НА-СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Нийгмийн даатгалын хэлтсийн 3 ажилтан ээлжийн амралтын олговор, цалинг давхардуулан авсан.	1.3	Төлбөрийн акт	НДХ-ийн дарга, ахлах нягтлан бодогч, үйл ажиллагааны нягтлан бодогч	Б.Анар, Л.Эрдэнэсүвд Э.Нямсүрэн
2	Магадлагч эмчид 2,374,596 төгрөгийн тэтгэмж олгоходоо үндсэн цалингийн зардлаас олгосон.	2.4	Албан шаардлага	НДХ-ийн дарга, ахлах нягтлан бодогч, үйл ажиллагааны нягтлан бодогч	Б.Анар, Л.Эрдэнэсүвд Э.Нямсүрэн
3	НДЕГ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/177 дугаар тушаалаар Киоск тоног төхөөрөмжийг орон нутгийн НДХ-т нийлүүлж үндсэн хөрөнгөд бүртгэж тооллогод байгаагаар тоолсон боловч хөрөнгө бодитоор ирээгүй байна.	2.5	Албан шаардлага	НДХ-ийн дарга, ахлах нягтлан бодогч, үйл ажиллагааны нягтлан бодогч	Б.Анар, Л.Эрдэнэсүвд Э.Нямсүрэн
4	Сангийн сайдын 388 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгыг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй.		Зөвлөмж	НДХ-ийн дарга, ахлах нягтлан бодогч, үйл ажиллагааны нягтлан бодогч	Б.Анар, Л.Эрдэнэсүвд Э.Нямсүрэн
5	Нийгмийн даатгалын сан нь өмнөх онд 14,071.5 сая төгрөгийн авлагатай байсан бол 2,479.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 16,550.8 сая төгрөг болсон. Өр төлбөр 386.8 сая төгрөгөөс 16.1 сая төгрөг болж буурсан байна. Бүртгэлтэй өглөг, авлагын тооцооноос насжилт ихтэй 2017, 2018,		Зөвлөмж	НДХ-ийн дарга, ахлах нягтлан бодогч, үйл ажиллагааны нягтлан бодогч	Б.Анар, Л.Эрдэнэсүвд Э.Нямсүрэн

	2019 онуудад үүссэн авлага 1,760.9 сая төгрөг, ер төлбөрийн 16.15 сая төгрөг бүрэн барагдаагүй байна.				
6	НДЕГ-ын 2018 оны А/22 дугаар тушаалаар Орхон аймгийн НДХ-ийн бүтэц орон тоог 38 ажилтантай, орлого шимтгэлийн тасаг 9 хүний бүрэлдэхүүнтэй, сумын байцаагч 1 нийт 10 байхаар батлагдсан. Байгууллагын төсөвт орлогын тасгийн байцаагчийн урамшуулал 360.0 мянган төгрөгөөр бодож нийт 2,880.0 мянган төгрөг батлагдсан. Гүйцэтгэлээр 14 ажилтанд 205,700 төгрөгийн урамшуулал олгосон нь НДЕГ-аас баталсан бүтэц орон тоог баримтлаагүй байна.	2.9	Албан шаардлага	НДХ-ийн дарга, ахлах нягтлан бодогч, үйл ажиллагааны нягтлан бодогч	Б.Анар, Л.Эрдэнэсүвд Э.Нямсүрэн
	Дүн	9.1			



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 32/32 ОИА-2022/1/НА-СТА-ТШЭ Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сангийн ерөнхий нягтлан бодогч нь 2021 оны 4 дүгээр сард ээлжийн амралтын нөхөн олговроо цалинтай хамт авсан бол дараа сарын цалин бүтэн бодогдож 8 сард ээлжийн амралтын 15 хоногийг суутган тооцсон байтал үлдсэн 5 хоногийн цалин 328,445 төгрөгийг давхардуулан олгосон.

2. Тэтгэврийн байцаагч нь ажлын 24 хоногийн ээлжийн амралтын нөхөн олговроо 7 дугаар сард бодуулж авсан. 7 дугаар сард 18 хоног амарч, 8 дугаар сараас эхлэн цалинг бүтэн ажилласнаар бодож, ээлжийн амралтын 6 хоногийн 332,178 төгрөгийн цалин давхардуулан олгосон.

3. Хамралт орлого шимтгэлийн тасгийн дарга нь 2021 оны 8 дугаар сард 24 хоногийн ээлжийн амралтын нөхөн олговроо авсан. 08 дугаар сард 15 хоног амарч, дараа саруудад цалин бүтэн бодогдож 9 хоногийн 683,730 төгрөгийн цалин давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм

хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нийгмийн даатгалын хэлтэс нь ээлжийн амралтын нөхөн олговор, цалинг давхардуулан олгосон 1,344,353 төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Б.Анар, сангийн ахлах нягтлан бодогч Л.Эрдэнэсүвд, үйл ажиллагааны нягтлан бодогч Э.Нямсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР:..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР:..... Т.БОЛОРМАА

¹ Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-0757



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2021 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 01/61 ОРА-5032/01/НА-СТА-ТЦ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/177 дугаар тушаалаар 2,480.0 мянган төгрөгийн Киоск тоног төхөөрөмжийг орон нутгийн Нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгч үндсэн хөрөнгөд орлогоор бүртгэж, оны эцсийн хөрөнгийн тооллогод байгаагаар тоолсон боловч Киоск тоног төхөөрөмж нь бодитоор ирээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-т “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Бодитоор оршин байхгүй 2,480.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаж тайлагнасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Б.Анар, ахлах нягтлан бодогч Л.Эрдэнэсүвд, үйл ажиллагааны нягтлан бодогч Э.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: Т.БОЛОРМАА





ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 62/22 ОАА-9098/01/НХ 15112 Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2021 оны 67 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийн 10.3-т "Төв болон орон нутгийн комиссын бүрэлдэхүүнд гурваас дээш жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан магадлагч эмч, төв комиссын дарга, нарийн бичгийн даргад 3 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас 3 жил тутамд олгоно" гэж заасны дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Б/67 тушаалаар магадлагч эмчид 2,374,596 төгрөгийн тэтгэмжийг үндсэн цалингийн зардлаас олгож төсвийг зориулалт бус зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" зааврын 210101-Үндсэн цалин "Цалингийн сүлжээ, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа үндсэн болон байнгын гэрээт ажилтны алан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-т "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цалингийн зардлаас зориулалт бусаар 2,374,596 төгрөгийн тэтгэмж олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Б.Анар, ахлах нягтлан бодогч Л.Эрдэнэсүвд, үйл ажиллагааны нягтлан бодогч Э.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: Т.БОЛОРМАА



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 63/63 ОРА-2021/01/НН-САН ТЦ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/22 дугаар тушаалаар Орхон аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн бүтэц орон тоог 38 ажилтантай, үүнээс орлого шимтгэлийн тасаг 9 хүний бүрэлдэхүүнтэй, сумын байцаагч 1 нийт 10 орон тоотой байхаар баталсан. Байгууллагын төсөвт орлогын тасгийн байцаагчийн урамшуулалд нэг ажилтанд 360.0 мянган төгрөгөөр бодож 9 ажилтанд нийт 2,880.0 мянган төгрөг олгохоор батлагдсан. Харин гүйцэтгэлээр урамшууллыг 14 ажилтанд 205,700 төгрөг олгосон нь НДЕГ-аас баталсан бүтэц орон тоог баримтлан ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Нийгмийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйл "Нийгмийн даатгалын байгууллагын удирдлага"-ын 1-д "Нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний, орон нутгийн байгууллага нь тухайн шатны Засаг дарга болон нийгмийн даатгалын дээд шатны байгууллагын удирдлагын дор ажиллана", Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 354 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм"-ийн 4.1-т "Аймаг, нийслэл, сум, дүүргийн нийгмийн даатгалын газар, хэлтэс, тасаг, ажилтан дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ", 4.1.10-т "дээд шатны байгууллага, албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг хэрэгжүүлэх, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар

тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-т “ байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газраас баталсан бүтэц, орон тоогоор ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Б.Анар, ахлах нягтлан бодогч Л.Эрдэнэсүвд, үйл ажиллагааны нягтлан бодогч Э.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..... Т.БОЛОРМАА